



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2023 оны 07 сарын 21-ны
өдрийн 6318 дугаарт бүртгэв.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа
эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага” батлах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.9, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэлэн ТОГТООХ нь:

1. “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү нөхцөл, шаардлага хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518000843

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ТАВИХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хадгаламж, зээлийн хоршоо (цаашид "ХЗХ" гэх)-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа, түүнд тавих нөхцөл, шаардлага, Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоонд тавигдах шаардлагыг энэ журмаар зохицуулна. *Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 505 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан.*

1.2. Энэхүү нөхцөл, шаардлага нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

ХОЁР. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ШААРДЛАГА

2.1. ХЗХ нь үйл ажиллагаандаа хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж дараах шаардлагыг хангана:

2.1.1. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтлах;

2.1.2. Бүх гишүүдийн ээлжит хурлыг хуулийн хугацаанд зарлан хуралдуулж Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан бүх гишүүдийн хурлын бүрэн эрхийн асуудлуудыг бүрэн хэлэлцүүлж, холбогдох шийдвэрүүдийг гаргах, хуралдааны тэмдэглэлийг хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу хөтөлж хурал хуралдсанаас хойш 30 хоногийн дотор Хороонд хүргүүлэх;

2.1.3. Хорооноос тогтоосон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах;

2.1.4. Актив хөрөнгийг холбогдох журмын дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулах;

2.1.5. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтлөх;

2.1.6. Санхүүгийн тайланг Аудитын тухай хуульд заасны дагуу баталгаажуулах;

2.1.7. Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хугацаанд нь төвлөрүүлэх;

2.1.8. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.1.9. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 46.2-т заасны дагуу санхүүгийн болон зохистой харьцааны тайлан, статистик мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд зохих маягтын дагуу гаргаж Хороонд хүргүүлэх;

2.1.10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу харилцагч/гишүүнийг таньж мэдэх ажиллагааг гүйцэтгэж, эцсийн өмчлөгчийг тогтоох арга хэмжээ авах, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны <https://goaml.mongolbank.mn/> цахим системд бүртгүүлэн сэжигтэй гүйлгээг 24 цагийн дотор, 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүн бүхий бэлэн мөнгөний

гүйлгээний мэдээллийг ажлын 5 хоногийн дотор мэдээлэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулгыг хагас жил тутам Хороонд цахимаар хүргүүлэх;

2.1.11. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д заасны дагуу хоршооны үйл ажиллагааны онцлогт нийцсэн “Дотоод хяналтын хөтөлбөр”-ийг боловсруулан бүх гишүүдийн хурлаар батлах, энэхүү хуулийн 14.4.11-т заасны дагуу дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилон, тогтмол хяналт тавьж ажиллах;

2.1.12. Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй мэдээлэл өгөх, авах гэрээг байгуулах, зээлдэгч гишүүдийн мэдээллийг тогтмол нийлүүлэх, зээл олгох бүр мэдээллийн сангаас лавлагаа авч зээлийн эрсдэлээс сэргийлж ажиллах;

2.1.13. Хадгаламж болон зээлийн үйл ажиллагааны бодлогыг бүх гишүүдийн хурлаар батлах, уг бодлогод нийцүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах хадгаламжийн болон зээлийн үйл ажиллагааны журмыг тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар баталж мөрдүүлэх;

2.1.14. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Хорооноос баталсан журам, заавар, загвар, зөвлөмжийн дагуу холбогдох дотоод журам, заавар, аргачлалыг бүх гишүүдийн хурал болон тэргүүлэгчдийн зөвлөлөөр баталж мөрдөх;

2.1.15. Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал болон салбарын захирал нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34.3, 34.4, 34.11, 36.5, 38.5, 39.6, Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;

2.1.16. Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал болон салбарын захирал нь сонгогдож, томилогдсоноос хойш 6 сарын хугацаанд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх;

2.1.17. Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, салбарын захирал болон нягтлан бодогч өөрчлөгдсөн бол энэхүү нөхцөл, шаардлагын 5 дугаар хавсралтын дагуу гаргасан өргөдөл, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасан шаардлагыг хангасан болохыг нотлох баримтын хамт ажлын 10 өдрийн дотор Хороонд бичгээр мэдэгдэх;

2.1.18. ХЗХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах 2-оос доошгүй ажилтан (гүйцэтгэх захирал болон нягтлан бодогч эсхүл гүйцэтгэх албаны бусад ажилтан)-тай байх;

2.1.19. Үйл ажиллагаа явуулах ажлын байр болон салбарын ажлын байр, техник, тоног төхөөрөмж, санхүүгийн программ хангамж нь тухайн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, шаардлагыг хангасан байх;

2.1.20. Үйл ажиллагаа явуулах ажлын байр болон салбарын ажлын байр нь барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулсан байх;

2.1.21. Санхүүгийн бэлэн бус гүйлгээг зөвхөн ХЗХ-ны нэр дээрх арилжааны банкин дахь дансаар хийх;

2.1.22. ХЗХ нь гишүүдийн бүртгэлийг тогтмол хөтлөх ба гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэл болон хувь хөрөнгийн өөрчлөлтийн мэдээллийг хагас, бүтэн жилээр Хороонд мэдэгдэх;

2.1.22.1. Гишүүн хувь хүн бол бүртгэлд овог, нэр, регистрийн дугаар, хаяг, холбоо барих утас, оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, гишүүнээр элссэн огноо зэрэг мэдээллүүд багтсан байна.

2.1.22.2. Гишүүн хуулийн этгээд бол бүртгэлд хуулийн этгээдийн регистрийн дугаар, хувьцаа эзэмшигчдийн тоо, хувьцаа эзэмшигчийн овог нэр, регистрийн дугаар, оруулсан хувь хөрөнгийн хэмжээ зэрэг мэдээллүүд багтсан байна.

2.1.23. Гишүүдийн оруулж буй хувь хөрөнгө тухайн иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны үйл ажиллагаанаас бий болсон орлого эсэхийг ХЗХ нь тухай бүр нягталдаг байх;

2.1.24. Салбар нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан гишүүнчлэлийн нөхцөлийг хангасан байх;

2.1.25. ХЗХ нь албан ёсны цахим шуудангийн хаяг /ХЗХ-ны нэрийг тусгасан/-тай байх, өөрчилсөн бол ажлын 5 өдрийн дотор Хороонд мэдэгдэх;

2.1.26. ХЗХ нь оноосон нэрээ өөрчилсөн тохиолдолд энэхүү нөхцөл, шаардлагын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан өргөдөл, бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн шийдвэр, ХЗХ-ны дүрэмд тусгасан шинэчилсэн дүрэм болон бүх гишүүдэд оноосон нэрийн өөрчлөлтийн талаар мэдээлснийг нотлох баримтын хамт ажлын 5 өдрийн дотор Хороонд мэдэгдэх;

2.1.27. Ажлын байрны хаяг байршил өөрчлөгдсөн тохиолдолд энэхүү нөхцөл, шаардлагын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан өргөдөл, бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн шийдвэр, ХЗХ-ны дүрэмд тусгасан шинэчилсэн дүрэм болон бүх гишүүдэд хаяг байршлын өөрчлөлтийн талаар мэдээлснийг нотлох баримтын хамт ажлын 7 өдрийн дотор Хороонд бичгээр мэдэгдэх;

2.1.28. ХЗХ нь салбар байгуулсан тохиолдолд энэхүү нөхцөл, шаардлагын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан өргөдөл, бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн шийдвэр, ХЗХ-ны дүрэмд тусгасан шинэчилсэн дүрэм болон бүх гишүүдэд салбарын талаар мэдээлснийг нотлох баримтын хамт ажлын 7 өдрийн дотор Хороонд бичгээр мэдэгдэх.

ГУРАВ. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ТАВИХ НӨХЦӨЛ

3.1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн этгээд нь Зөвшөөрлийн тухай хууль болон Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасны дагуу доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

3.1.1. Зөвшөөрөл хүссэн албан бичиг;

3.1.2. Энэхүү нөхцөл, шаардлагын 1 дүгээр хавсралтын дагуу гаргасан зөвшөөрөл хүссэн өргөдөл;

3.1.3. Үүсгэн байгуулагчдын хурлын тэмдэглэл, шийдвэр /үүсгэн байгуулагчдын ирцийн бүртгэлийг хуралд оролцсон гишүүдийн гарын үсгээр баталгаажуулсан байх/;

3.1.4. Үүсгэн байгуулагчдын хурлаас Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн баталсан ХЗХ-ны дүрэм, хадгаламжийн болон зээлийн бодлого, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны ажиллах журам, уг дүрэм, журмыг баталсан хурлын тэмдэглэл, шийдвэр;

3.1.5. Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар баталсан хадгаламжийн болон зээлийн үйл ажиллагааны журам, журмыг баталсан хурлын тэмдэглэл, шийдвэр;

3.1.6. Гишүүдийн оруулж буй хувь хөрөнгө нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан, хууль ёсны үйл ажиллагаанаас бий болсон орлого болохыг нотлох баримт, тайлбар тодруулгыг ирүүлэх ба уг мөнгөн хөрөнгийг ХЗХ-ны банкин дахь харилцах дансанд байршуулах;

3.1.7. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34, 36 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн томилсон тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга, гишүүд, хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилсон тухай бүх гишүүдийн хурлын тэмдэглэл шийдвэр, эдгээр албан тушаалтнуудын энэхүү нөхцөл, шаардлагын 2 дугаар хавсралтын дагуу гаргасан анкет;

3.1.8. ХЗХ-ны үүсгэн байгуулагч гишүүн бүр Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгыг бүрэн гүйцэт, үнэн зөв гаргах;

3.1.9. ХЗХ-ны сонгуульт гишүүд, гүйцэтгэх захирал болон 20 сая төгрөг, түүнээс дээш оруулсан хувь хөрөнгө бүхий гишүүд эцсийн өмчлөгчийг тодорхойлох асуулгыг бүрэн гүйцэт, үнэн зөв гаргах;

3.1.10. Энэхүү нөхцөл, шаардлагын 3 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн санхүүгийн эхлэлтийн тайлан тэнцэл;

3.1.11. Бүх гишүүдийн хурлаар баталсан 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө;

3.1.12. Шаардлагатай тохиолдолд тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга, гишүүн, хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, зээлийн хорооны дарга, гишүүн, гүйцэтгэх захирлын орон нутгийн хөгжил, хоршооны талаар мэдлэг, туршлагатайг нотлох тодорхойлолт;

3.1.13. Гүйцэтгэх захирлыг томилсон тухай тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, тэргүүлэгчдийн зөвлөлийн даргатай байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон энэхүү нөхцөл, шаардлагын 2 дугаар хавсралтын дагуу гаргасан анкет;

3.1.14. Нягтлан бодогчийг томилсон тухай гүйцэтгэх захирлын тушаал, гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээ болон энэхүү нөхцөл, шаардлагын 2 дугаар хавсралтын дагуу гаргасан анкет;

3.1.15. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах “Дотоод хяналтын хөтөлбөр”, дотооддоо мөрдөх журмыг бүх гишүүдийн хурлаар баталсан тэмдэглэл, шийдвэр, тус дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилсон гүйцэтгэх захирлын тушаал;

3.1.16. Үйл ажиллагаа явуулах ажлын байр нь түрээсийн бол түрээсийн гэрээ, өөрийн өмчлөлийн бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар.

ДӨРӨВ. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Үндэсний холбоо дараах шаардлагыг хангана:

4.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт хадгаламж, зээлийн хоршоодын 51-ээс доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх;

4.1.2. Хоршооны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан Хоршооллын нэгдсэн холбоонд гишүүнээр элссэн байх;

4.1.3. Адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагатай хамтран ажилладаг эсхүл гишүүнчлэлтэй байх;

4.1.4.Хадгаламж, зээлийн хоршооны салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг баталсан байх;

4.1.5.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т заасан шаардлагыг дүрэмдээ тусгасан байх.

4.2.Үндэсний холбоог энэ журамд тавигдсан шаардлагыг хангасан эсэхийг Хорооны хуралдаанаар тодорхойлж, санамж бичиг байгуулан хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллана.”

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны
6 дугаар сарын 30-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор
батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа
эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын нэгдүгээр хавсралт

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

| | | | |
|--|---|----------|---|
| Өргөдөл гаргасан огноо | Он | Сар | Өдөр |
| Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан эсэх | | | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> |
| Тийм бол хаана, ямар үйл ажиллагааг, ямар хугацаагаар эрхэлсэн талаар бичих | | | |
| Өмнө нь тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлж байсан эсэх | | | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> |
| Тийм бол хэзээ ирүүлсэн, хэрхэн шийдвэрлэсэн талаар бичих | | | |
| I. ХЗХ-ны ерөнхий мэдээлэл | | | |
| ХЗХ-ны нэр: | Монгол | | |
| | Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичих) | | |
| Оноосон нэрд орсон өөрчлөлт /хэрэв өөрчлөгдөж байсан бол/ | Нэр _____ | | |
| | Хэзээнээс ____ / ____ / ____ хүртэл ____ / ____ / ____ (Оноосон нэр өөрчлөгдсөн бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэрийг хэрэглэсэн талаарх хугацааг он/сар/өдөр дарааллаар бичих) | | |
| Үүсгэн байгуулагдсан огноо | ____ /он/ ____ /сар/ ____ /өдөр/ (Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан хурлын огноог бичих) | | |
| Улсын бүртгэлийн дугаар | | | |
| Регистрийн дугаар | | | |
| ХЗХ-ны гишүүдийн тоо | | | |
| Гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөг/ | | | |
| Харилцах <input type="checkbox"/> | Банкны нэр | | |
| | Дансны дугаар | | |
| | Үлдэгдэл /төгрөг / | | |
| Хадгаламж <input type="checkbox"/> | Банкны нэр | | |
| | Дансны дугаар | | |
| | Үлдэгдэл /төгрөг/ | | |
| Хаяг байршил: | Аймаг/ хот | | |
| | Сум/дүүрэг | | |
| | Баг/хороо | | |
| | Гудамж, байр | | |
| | Тоот | | |
| Холбоо барих утас: | Суурин | Гар утас | Факс |
| | | | |
| Цахим хуудас: | | | |
| Цахим шуудан: | | | |

ХЗХ-ны гишүүнчлэлийн хамрах хүрээ (Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан дараах нөхцөлүүдээс тохирохыг сонгож “√” тэмдгийг тавих)

- Нэг байгууллагад ажилладаг
 Үйл ажиллагааны чиглэл адил нийгэмлэг, холбоонд гишүүнчлэлтэй
 Нэг сум/ хорооны харьяалалтай
 Нэг дүүрэгт харьяалалтай
 Нэг хот/ аймгийн харьяалалтай

II. Үүсгэн байгуулагч гишүүдийн мэдээлэл (Овог, нэр, регистрийн дугаарыг үнэн зөв, гаргацтай, бүтнээр бичиж, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны дэлгэрэнгүй хаяг, хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн дүнг бичих)

| № | Овог, нэр | Регистрийн дугаар | Оршин суух хаяг, холбоо барих утас | Хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөг/ |
|-----|-----------|-------------------|------------------------------------|----------------------------------|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | | | | |
| 4 | | | | |
| 5 | | | | |
| ... | | | | |

Тэмдэглэл: Үүсгэн байгуулагч гишүүн бүрийг жагсаан бичих

III. Сонгуульт болон гүйцэтгэх удирдлагын мэдээлэл

а/ Тэргүүлэгчдийн зөвлөлийн бүрэлдэхүүн

| № | Овог, нэр | Дарга / гишүүн | Регистрийн дугаар | Ажлын хаяг, холбоо барих утас | Боловсролын байдал | | |
|-----|-----------|----------------|-------------------|-------------------------------|--------------------|-----------------|----------|
| | | | | | Төгссөн сургууль | Дипломын дугаар | Мэргэжил |
| 1 | | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| ... | | | | | | | |

Тэмдэглэл: Зөвлөлийн гишүүн бүрийг бичих

б/ Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн

| № | Овог, нэр | Дарга / гишүүн | Регистрийн дугаар | Ажлын хаяг, холбоо барих утас | Боловсролын байдал | | |
|-----|-----------|----------------|-------------------|-------------------------------|--------------------|-----------------|----------|
| | | | | | Төгссөн сургууль | Дипломын дугаар | Мэргэжил |
| 1 | | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| ... | | | | | | | |

Тэмдэглэл: Зөвлөлийн гишүүн бүрийг бичих

в/ Зээлийн хорооны бүрэлдэхүүн

| № | Овог, нэр | Дарга / гишүүн | Регистрийн дугаар | Ажлын хаяг, холбоо барих утас | Боловсролын байдал | | |
|---|-----------|----------------|-------------------|-------------------------------|--------------------|-----------------|----------|
| | | | | | Төгссөн сургууль | Дипломын дугаар | Мэргэжил |
| 1 | | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |

| | | | | | | | |
|-----|--|--|--|--|--|--|--|
| 5 | | | | | | | |
| ... | | | | | | | |

Тэмдэглэл: Хорооны гишүүн бүрийг бичих

г/ Гүйцэтгэх албаны бүрэлдэхүүн

| № | Албан тушаал | Овог, нэр | Регистрийн дугаар | Оршин суух хаяг, холбоо барих утас | Боловсролын байдал | | |
|-----|--------------|-----------|-------------------|------------------------------------|--------------------|-----------------|----------|
| | | | | | Төгссөн сургууль | Дипломын дугаар | Мэргэжил |
| 1 | | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| ... | | | | | | | |

Тэмдэглэл: Албан тушаалтан бүрийг бичих

IV. Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл

- Худалдаж авсан
- Түрээсэлсэн
- Ажлын байрны гаднах талбайн аюулгүй байдлыг хангасан эсэх
- Бусад /тохирохыг сонгож “√” тэмдгийг тавих./

Тэмдэглэл: үйл ажиллагаа явуулах ажлын байр нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дэх хаяг байришил, дүрэмд тусгагдсан хаяг байришилтай ижил байх

V. Ашиглах техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл

| № | Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл | Техникийн үзүүлэлт | Худалдан авсан | Түрээсэлсэн | Тоо ширхэг | Үнэ |
|-----|--------------------------------------|--------------------|--------------------------|--------------------------|------------|-----|
| 1 | | | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | | |
| 2 | | | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | | |
| 3 | | | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | | |
| ... | | | | | | |

Тэмдэглэл: Техник, тоног төхөөрөмж бүрээр бичих

VI. Ашиглах программ хангамжийн мэдээлэл

| № | Программ хангамжийн нэр төрөл | Зориулалт | Худалдан авсан | Түрээсэлсэн | Тоо ширхэг | Үнэ |
|-----|-------------------------------|-----------|--------------------------|--------------------------|------------|-----|
| 1 | | | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | | |
| 2 | | | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | | |
| ... | | | | | | |

Тэмдэглэл: Программ хангамж бүрээр бичих

VII. Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн төлөвлөлт (өссөн дүнгээр)

| Үзүүлэлтүүд | _____ он | _____ он | _____ он |
|-------------------------------|----------|----------|----------|
| Эрхлэх үйл ажиллагааны чиглэл | | | |
| Нийт хөрөнгө | | | |
| Өөрийн хөрөнгө | | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | | | |
| Бусдаас татсан эх үүсвэр | | | |
| Нийт орлого | | | |
| Нийт зарлага | | | |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | | | |
| Активын өгөөж | | | |

Тэмдэглэл: Бизнес төлөвлөгөөтэй уялдуулан тодорхойлох

Өргөдөл гаргасан: Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга

Овог, нэр

гарын үсэг

огноо


Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны
6 дугаар сарын 30-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор
батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа
эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын хоёрдугаар хавсралт



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ СОНГУУЛТ ГИШҮҮН
БОЛОН ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

1. Ерөнхий мэдээлэл

| | |
|--|--|
| Ургийн овог: | |
| Овог: | |
| Нэр: | |
| Регистрийн дугаар: | |
| Иргэний харьяалал: | |
| ХЗХ-нд эрхлэх сонгуульт болон гүйцэтгэх албан тушаал: | |
| Оршин суугаа газрын хаяг: | |
| Гар утасны дугаар: | |
| Цахим шуудан: | |
| Эрхэлж байгаа ажил, албан тушаал: | |
| Ажлын хаяг: | |
| Цахим шуудан: | |



2. Боловсролын байдал /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

| № | Төгссөн сургууль | Эзэмшсэн мэргэжил | Элссэн он | Төгссөн он | Диплом, гэрчилгээний дугаар |
|---|------------------|----------------------|-----------|------------|-----------------------------------|
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| 4 | | | | | |
| 5 | | | | | |

3. Ажлын туршлага

| № | Хаана ажиллаж байсан | Албан тушаал | Ажилд орсон он, сар, өдөр | Ажлаас гарсан он, сар, өдөр | Шалтгаан |
|---|-------------------------|--------------|---------------------------------|-----------------------------------|----------|
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| 4 | | | | | |
| 5 | | | | | |

4.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 3.1.4-т заасан “нэгдмэл сонирхолтой этгээд”-ийн мэдээлэл /хадгаламж, зээлийн хоршооны гишүүн, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл болон зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтантай эд хөрөнгө, садан төрлийн зэрэг хувийн ашиг сонирхлын холбоо бүхий этгээд/

| № | Ямар хамааралтай болох | Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Эрхэлж буй ажил, албан тушаал |
|---|------------------------|-----------------------------------|-------------------|-------------------------------|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | | | | |
| 4 | | | | |
| 5 | | | | |

Тодорхойлолт гаргасан:

Албан тушаал

Овог, нэр

гарын үсэг

огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны
6 дугаар сарын 30-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор
батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа
эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын гуравдугаар хавсралт



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ
ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

| | |
|------------------------------------|--|
| Тусгай зөвшөөрөл хүсэгч ХЗХ-ны нэр | |
|------------------------------------|--|

| ХӨРӨНГӨ | ДҮН | ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ | ДҮН |
|--|-----|-------------------------------------|-----|
| САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ | | НИЙТ ӨР ТӨЛБӨР | |
| <i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</i> | | <i>Санхүүгийн өр төлбөр</i> | |
| Бэлэн мөнгө | | Дансны өглөг | |
| Банканд байгаа мөнгө | | Бусад санхүүгийн өр төлбөр | |
| Дансны авлага | | <i>Санхүүгийн бус өр төлбөр</i> | |
| <i>Бусад санхүүгийн хөрөнгө</i> | | Хойшлогдсон татварын өр төлбөр | |
| | | Хойшлогдсон орлого | |
| | | Бусад санхүүгийн бус өр төлбөр | |
| САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ | | ӨМЧ /ӨӨРИЙН ХӨРӨНГӨ/ | |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | Гишүүний оруулсан хувь хөрөнгө | |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | | Өмчийн бусад хэсэг | |
| Үндсэн хөрөнгө | | Тусгай зориулалтын нөөцийн сангууд | |
| Биет бус хөрөнгө | | Хуримтлагдсан ашиг/алдагдал | |
| Нийт хөрөнгийн дүн | | Нийт өр төлбөр ба өмчийн дүн | |

Гүйцэтгэх захирал

Гарын үсэг

Огноо

Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 505 дугаар тогтоолоор өөрчилсөн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны
6 дугаар сарын 30-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор
батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа
эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын дөрөвдүгээр хавсралт

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ОНООСОН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ, САЛБАР
БАЙГУУЛАХ БОЛОН ХАЯГ БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХ МАЯГТ**

| | | | | | | |
|---|--|--|-------------------------------|--|--------------|--|
| Мэдэгдэл ирүүлсэн огноо | Он | | Сар | | Өдөр | |
| ХЗХ-ны нэр | | | | | | |
| Регистрийн дугаар | | | | | | |
| Өөрчлөлтийн талаар мэдээллийн төрлийг сонгох (тохирох нүдэнд “√” тэмдгийг тавих) | | | | | | |
| <input type="checkbox"/> 1. Оноосон нэрийн өөрчлөлтийн талаар мэдээлэл <input type="checkbox"/> 2. Салбар байгуулсан талаар мэдээлэл <input type="checkbox"/> 3. Хаяг, байршлын өөрчлөлтийн талаар мэдээлэл | | | | | | |
| 1. Оноосон нэрийн өөрчлөлтийн талаар | | | | | | |
| Оноосон нэр өөрчлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар | _____ /он/ | | _____ /сар/ | | _____ /өдөр/ | |
| | Шийдвэрийн хуулбар, хурлын тэмдэглэлийг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | |
| ХЗХ-ны шинэ нэр | Нэр _____ (Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан шинэ нэрийн баталгаажуулалтын хуудаст тусгагдсан нэрийг бичих) | | | | | |
| ХЗХ-ны дүрэмд тусган шинэчилсэн дүрмийг ирүүлсэн эсэх | Тийм <input type="checkbox"/> | | Үгүй <input type="checkbox"/> | | | |
| Бүх гишүүдэд оноосон нэрийн өөрчлөлтийг мэдээлсэн эсэх | Тийм <input type="checkbox"/> | | Үгүй <input type="checkbox"/> | | | |
| | Бүх гишүүдэд оноосон нэрийн өөрчлөлтийг мэдээлсэн талаар нотлох баримтыг хавсаргасан эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | |
| 1. Салбар байгуулсан талаар мэдээлэл | | | | | | |
| Салбар байгуулах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар | _____ /он/ | | _____ /сар/ | | _____ /өдөр/ | |
| | Шийдвэрийн хуулбар, хурлын тэмдэглэлийг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | |
| Салбарын хаяг байршил | Аймаг/хот | | | | | |
| | Сум/дүүрэг | | | | | |
| | Баг/Хороо | | | | | |
| | Гудамж, байр | | | | | |
| | Тоот | | | | | |
| | Цахим шуудан | | | | | |
| | Холбоо барих утас | | | | | |

| ХЗХ-ны дүрэмд тусган шинэчилсэн дүрмийг ирүүлсэн эсэх | | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | |
|--|--------------------------------------|--|--|------------------------------------|--------------------|-----------------|----------|
| Бүх гишүүдэд салбар байгуулсан талаар мэдээлсэн эсэх | | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | |
| | | Бүх гишүүдэд салбар байгуулсан талаар мэдээлсэн эсэхийг нотлох баримтыг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | |
| Салбарын боловсон хүчний мэдээлэл (<i>Овог, нэр, регистрийн дугаарыг үнэн зөв, гаргацтай, бүтнээр бичиж, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны дэлгэрэнгүй хаяг, боловсролын байдлыг бичих</i>) | | | | | | | |
| № | Албан тушаал | Овог, нэр | Регистрийн дугаар | Оршин суух хаяг, холбоо барих утас | Боловсролын байдал | | |
| | | | | | Төгссөн сургууль | Дипломын дугаар | Мэргэжил |
| 1 | | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| ... | | | | | | | |
| <i>Тэмдэглэл: Албан тушаалтан бүрийг жагсаан бичих</i> | | | | | | | |
| Салбарын захирал нь энэхүү нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэх | | | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | |
| | | | Салбарын захирал нь энэхүү нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлох баримтыг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | |
| Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл | | | Худалдаж авсан <input type="checkbox"/> Түрээсэлсэн <input type="checkbox"/> | | | | |
| | | | Нотлох баримтыг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | |
| Салбарт ашиглах техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл | | | | | | | |
| № | Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл | Техникийн үзүүлэлт | Худалдан авсан | Түрээсэлсэн | Тоо ширхэг | Үнэ | |
| 1 | | | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | | | |
| 2 | | | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | | | |
| .. | | | | | | | |
| . | | | | | | | |
| <i>Тэмдэглэл: Техник, тоног төхөөрөмж бүрээр бичих</i> | | | | | | | |
| Салбарт ашиглах программ хангамжийн мэдээлэл | | | | | | | |
| № | Программ хангамжийн нэр төрөл | Зориулалт | Худалдан авсан | Түрээсэлсэн | Тоо ширхэг | Үнэ | |
| 1 | | | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | | | |
| 2 | | | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | | | |
| .. | | | | | | | |
| <i>Тэмдэглэл: Программ хангамж бүрээр бичих</i> | | | | | | | |
| 2. Хаяг, байршлын өөрчлөлтийн талаар мэдээлэл | | | | | | | |
| Хаяг, байршлыг өөрчлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын | | | _____ | | | _____ | |
| | | | /он/ | | | /сар/ | |
| | | | Шийдвэрийн хуулбар, хурлын тэмдэглэлийг ирүүлсэн эсэх | | | | |

| | | |
|---|--|--|
| шийдвэрийн огноо, дугаар | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | |
| Хаяг байршил | Аймаг/хот | |
| | Сум/дүүрэг | |
| | Баг/Хороо | |
| | Гудамж, байр | |
| | Тоот | |
| | Цахим шуудан | |
| | Холбоо барих утас | |
| <i>Тэмдэглэл: ХЗХ-ны шинэ хаяг, байршил нь тухайн хоршооны дүрэмд тусгагдсан байх</i> | | |
| ХЗХ-ны дүрэмд тусган шинэчилсэн дүрмийг ирүүлсэн эсэх | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | |
| Бүх гишүүдэд хаяг, байршлын өөрчлөлтийг мэдээлсэн эсэх | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | |
| | Бүх гишүүдэд хаяг, байршлын өөрчлөлтийг мэдээлсэн талаар нотлох баримтыг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | |

Мэдэгдэл хүргүүлсэн: Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга

Овог, нэр

гарын үсэг

огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны
6 дугаар сарын 30-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор
батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа
эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын тавдугаар хавсралт

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ СОНГУУЛЬТ ГИШҮҮД БОЛОН ГҮЙЦЭТГЭХ
АЛБАН ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХ МАЯГТ**

| Мэдэгдэл ирүүлсэн огноо | Он | | Сар | | Өдөр | | | |
|--|--|---|-----------|-------------------|------------------------------------|--------------------|-----------------|----------|
| ХЗХ-ны нэр | | | | | | | | |
| Регистрийн дугаар | | | | | | | | |
| Өөрчлөлтийн талаар мэдээллийн төрлийг сонгох (тохирох нүдэнд “√” тэмдгийг тавих) | | | | | | | | |
| <input type="checkbox"/> Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн <input type="checkbox"/> Хяналтын зөвлөлийн гишүүн <input type="checkbox"/> Зээлийн хорооны гишүүн <input type="checkbox"/> Гүйцэтгэх захирал <input type="checkbox"/> Салбарын захирал | | | | | | | | |
| 1. Шинэ сонгуульт гишүүдийн мэдээлэл | | | | | | | | |
| Сонгуульт гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар | /он/ | | /сар/ | | /өдөр/ | | | |
| | Шийдвэрийн хуулбар, хурлын тэмдэглэлийг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | | | |
| Гүйцэтгэх захирал, салбарын захирлыг томилсон тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэрийн огноо дугаар | /он/ | | /сар/ | | /өдөр/ | | | |
| | Шийдвэрийн хуулбар, хурлын тэмдэглэл болон гүйцэтгэх захирал, салбарын захиралтай байгуулсан гэрээг ирүүлсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | | | |
| <i>(Овог, нэр, регистрийн дугаарыг үнэн зөв, гаргацтай, бүтнээр бичиж, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны дэлгэрэнгүй хаяг, боловсролын байдлыг бичих)</i> | | | | | | | | |
| № | Албан тушаал | Сонгосон/ томилсон шийдвэрийн огноо | Овог, нэр | Регистрийн дугаар | Оршин суух хаяг, холбоо барих утас | Боловсролын байдал | | |
| | | | | | | Төгссөн сургууль | Дипломын дугаар | Мэргэжил |
| 1 | | | | | | | | |
| 2 | | | | | | | | |
| 3 | | | | | | | | |
| ... | | | | | | | | |
| <i>Тэмдэглэл: Албан тушаалтан бүрийг жагсаан бичих</i> | | | | | | | | |
| Сонгуульт гишүүд, гүйцэтгэх захирал, салбарын захирал нь энэхүү нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэх | | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | | |
| Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгыг ирүүлсэн эсэх | | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | | |
| Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгыг ирүүлсэн эсэх | | Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> | | | | | | |

Мэдэгдэл хүргүүлсэн: Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга

Овог, нэр

гарын үсэг

огноо